



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудит хийх үндэслэл: Үндэсний аудитын газрын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн дагуу хийв.

Аудитын ерөнхий дүгнэлт: Засгийн газраас хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээнүүд хугацаандаа хэрэгжээгүй байна.

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2014 ОНД САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН



Зуунмод
2015 он

АГУУЛГА

<u>Аудитын тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар	3
ҮАГ-ын харьяа Төв аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт	
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	БҮЛЭГ 1. Засгийн газраас хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнүүд хугацаандаа хэрэгжээгүй байна.	5
Аудитын менежер О.Амаржаргал	А.1 Зураг, төсөвгүй ажилд санхүүжилт батлагдснаас батлагдсан санхүүжилтэд багтаан төсөв хийж ажил гүйцэтгүүлж байна.	5
Аудитор Д.Пүрэвсүрэн Шинжээч Ч.Загдсүрэн	А.2 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсвийг бус хуулиар батлагдсан санхүүжилтийг тусгаж, мөрдөж байна.	11
2014 оны 10 дугаар сарын 20	А.3 Яамдаас худалдан авах ажиллагааг нь зохион байгуулсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт орон нутагт хангалтгүй хэрэгжиж байна.	13
Уг тайланг АГ-ын Веб сайтаас үзнэ үү. www.tuv-audit.mn	А.4 Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавьж буй захиалагчийн болон техник хяналт хангалтгүй байна.	15
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70273463 дугаарын утас, 70272582 дугаарын факсаар харилцана уу.	А.5 Орон нутагт салбар яамдтай гэрээ байгуулж ажил гүйцэтгэж байгаа, гэрээний үүргээ биелүүлээгүй компаниудтай хариуцлага тооцогдохгүй байна.	15
ХАЯГ:	БҮЛЭГ 2. Орон нутгийн төсвөөр хийгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь үр дүнтэй хэрэгжсэн байна.	17
Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	Б.1 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлууд нь орон нутгийн хэрэгцээ шаардлагыг хангасан байна.	19
	Б.2 Харьцуулалтын аргаар худалдан авах бараа, ажил, үйлчилгээг шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна.	19
	Б.3 Хөдөө орон нутгийн иргэд 3D кино театрт кино үздэг болсон байна.	21
	Б.4 Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавьж буй захиалагчийн болон техник хяналтын үйл ажиллагаа хангалтгүй байна.	22
	Б.5 107.8 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.	24
	Дүгнэлт	30
	Зөвлөмж	
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал	
	Холбогдох байгууллагын саналын дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ	

Товчилсон үгийн тайлбар	
МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их хурал
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ССАЖЯ	Соёл спорт аялал жуулчлалын яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХАА	Худалдан авах ажиллагаа
БХБА	Барилга хот байгуулалтын алба
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЭХЯ	Эрчим хүчний яам
ТББ	Тендерийн бичиг баримт

ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
--------------	--

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилт:

Төв аймгийн хэмжээнд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтэнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Үүнд :

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, үр дүнтэй хэрэгжсэн эсэх
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, үр дүнтэй хэрэгжсэн эсэх

Аудитын хамрах хүрээ:

Аудитаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн ерөнхийлөн захирагч, холбогдох байгууллага болон аймаг, орон нутгийн эрх бүхий байгууллагуудын хүрээнд шалгана.

Аудитын арга зүй:

Аудитын явцад холбогдох яам, агентлаг, аймгийн ЗДТГ-ын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авах, байгууллагын худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараахь хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт
- Төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Иргэний хууль
- Концессийн тухай хууль
- Дээрхи хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарсан УИХ, ЗГ-ын тогтоол, бусад эрхийн актууд
- Төсвийн хүрээний мэдэгдэл
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”

- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”

Аудит хийх бүрэлдэхүүн: Аудитыг аймгийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал удирдан, аудитор Д.Пүрэвсүрэн, шинжээч Ч.Загдсүрэн нар 2015 оны 1 дүгээр сарын 22-ноос 4-р сарын 15-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн үү?

Бүлэг 1 Засгийн газраас хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнүүд хугацаандаа хэрэгжээгүй байна.

А.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг Үндэсний хөгжлийн цогц бодлого, МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, ЗГ-ын мөрийн хөтөлбөртэй уялдуулан, ТЭЗҮ, баталгаажсан зураг төсвийг үндэслэн төлөвлөсөн үү?

Зураг, төсөвгүй ажилд санхүүжилт батлагдснаас батлагдсан санхүүжилтэд багтаан төсөв хийж ажил гүйцэтгүүлж байна.

2014 онд Төв аймагт “Монгол улсын 2014 оны төсвийн тухай хууль”-аар 7 сайдын багцаас нийт 9100.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 хөрөнгө оруулалт, их засварын ажилд 7450.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдснаас 1610.0 сая төгрөгийн өртөгтэй “Сумдын төвлөрсөн дулаан хангамж” төслийн ажлаас бусад 7490.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 ажилд 7000.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжиж хийгдсэн байна. “Сумдын төвлөрсөн дулаан хангамж” төсөл арга хэмжээний хүрээнд аймгийн Баяннөжүүл, Баянхангай, Өндөрширээт гэсэн 3 суманд 1610.0 сая төгрөгийн өртөгтэй халаалтын зуух, дулааны шугам сүлжээ барих төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар хийх төслийн шалгаруулалтыг ЭХЯам-наас зохион байгуулж, гэрээг ЭХЯам болон аймгийн Засаг дарга, түүний ЗДТГ, сумын Засаг дарга нартай байгуулжээ. Гэрээгээр улсын төсвөөс 450.0 сая төгрөг, компанийн өөрийн хөрөнгөөр 1160.0 сая төгрөгийн санхүүжилт хийхээр батлагджээ.

Эрх шилжиж хийгдсэн хөрөнгө оруулалт нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Монгол улсын 2014 оны төсвийн тухай хууль”-аар батлагдсан “Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд “Лүн сумын төвийн айл, өрх, албан байгууллагыг цэвэр, бохир, ус дулаанд холбох цэвэрлэх байгууламж байгуулах” 5.0 тэрбум төгрөгийн өртөгтэй төсөл, “Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кв-ын шугамын өргөтгөл, шинэчлэлт”-ийн ажлын хүрээнд хэрэгжүүлсэн 480.0 сая төгрөгийн өртөгтэй, 2014 оны төсвийн тухай хуулиар 240.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан 6 сумын 0.4 кв-ын шугамын шинэчлэл, нийт 5480.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5240.0 сая төгрөгийн санхүүжилттэй хөрөнгө оруулалтын ажил хийгджээ.

2. Аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргаас 2013 оны 6 сард ССАЖЯ-д 11687.0 сая төгрөгийн өртөгтэй 11 барилга, 8 сард ЗГХЭГ-т 3314.2 сая төгрөгийн өртөгтэй 8 барилга, ЭХЯ-д 30000.0 сая төгрөгийн 2 барилга, БШУ-ы сайдад 7.1 тэрбум төгрөгийн өртөгтэй 21 сургууль, цэцэрлэгийн 2014 онд барилга, байгууламж шинээр барих, их засвар хийх барилгын жагсаалтыг ач холбогдлын эрэмбээр жагсаан албан тоотоор хүргүүлсэн байна. Монгол улсын 2014 оны төсвийн тухай хуулиар 2010.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ажилд 1760.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан байна.

/Монгол улсын 2014 оны төсвийн тухай хуулиар/

			эхлэх	дуусах	Төсөвт өртөг	2014 онд санхүү жих дүн	Код	Тайлбар
1		ЗГХЭГазар						
	1	Цээл сумын ЗДТГ-ын иргэний танхимын барилгын ажлын санхүүжилт	2012	2014	600.0	350.0	X.1.4	
2		БШУ-ны сайд						
	1	Сургуулийн их засвар Бүрэн	2014	2014	100.0	100.0	XVI.2.2.56	
	2	Сургуулийн их засвар Баянцогт	2014	2014	100.0	100.0	XVI.2.2.57	
	3	Цэцэрлэгийн их засвар Баянжаргалан	2014	2014	150.0	150.0	XVI.2.2.58	
	4	Цэцэрлэгийн их засвар Баянхангай	2014	2014	100.0	100.0	XVI.2.2.60	
	5	5 сургуулийн спорт заалны их засвар	2014	2014	120.0	120.0	XVI.2.2.59	
3		ССАЖ-ын сайд						
	1	Архуст сумын соёлын төвийн барилгын их засвар	2014	2014	202.1	202.1	XVI.2.2.1	
	2	Эрдэнэсант сумын залуучуудын соёл, спортын төв	2014	2014	100.0	100.0	XVI.2.2.1	
4		Барилга, хот байгуулалтын сайд						
	1	Сумын төвийн айл өрх, албан байгууллагыг цэвэр, бохир, ус дулаанд холбох цэвэрлэх байгууламж барих /Лүн сум/	2014	2014	5000.0	5000.0	XVIII.1.59	
5		Эрчим хүчний сайд						
	1	Төв аймгийн сумдын 0.4 кв-ын шугамын шинэчлэл /Эрдэнэ, Заамар, Сэргэлэн, Цээл, Баян өнжүүл, Сүмбэр/	2014	2015	480.0	240.0	XX.1.1.48	240 сая төгрөг 2015 онд
		Сумдын төвлөрсөн дулаан хангамж төсөл, арга хэмжээ /Баянхангай, Баянөнжүүл, Өндөрширээт/	2014	2014	1610.0	450.0		Шалгаруулалтыг Эрчим хүчний яам зохион байгуулсан. Санхүүжилт нь аймгаар дамжиж хийгдсэн.
6		Хөдөлмөрийн сайд						
	1	МСҮТ-ийн барилгын дээврийн засвар Баянчандмань	2014	2014	327.3	327.3	XXII.1.2.2	
7		ЭМ, Спортын сайд						
	1	Баянцагаан сумын ЭМ-ийн төвийн барилгын засвар	2014	2014	100.0		XXIV.1.2.3	
	2	Сэргэлэн сумын ЭМ-ийн төв	2014	2014	78.0		XXIV.1.2.3	
	3	Архуст сумын ЭМ-ийн төв	2014	2014		178.0	XXIV.1.2.3	Эрүүл мэндийн сайдын 2014 оны 58 дугаар тушаалаар аймгийн Засаг дарга нарт эрх шилжүүлэн хэрэгжүүлэх их засварын ажлын жагсаалтад өөрчлөлт оруулсан.
	4	Баянжаргалан сумын ЭМТ-ийн барилгын халаалтын шугам	2014	2014	18.0	18.0	XXV.2.1.13	ЭМ-ийн сайдын 2014.08.28-ны өдрийн 288 тоот тушаалаар сайдын багцын

		сүлжээний засварын ажил						"Гэнэтийн хүчин зүйлийн дагуу хийгдэх засварын төсөв"-өөс эрх шилжиж хийгдсэн
	5	Алтанбулаг эмнэлгийн халаалтын тогооны шинэчлэл	2014	2014	15.0	15.0	XXV.2.1.13	
		Дүн			9100.4	7450.4		

2014 онд хийгдсэн 14 хөрөнгө оруулалт, их засварын ажлын хяналтын төсөвт өртөг нь 8120.2 сая төгрөг бөгөөд Монгол улсын 2014 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт өртөг нь 7490.4 сая төгрөг байна. "Төсвийн тухай хууль"-ийн 29.4-т "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төслөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана" гэсэн заалтын дагуу зураг төсөв нь хийгдэж, магадлалын дүгнэлт гаргуулж, зөвшөөрөгдсөн 1367.9 сая төгрөгийн хяналтын төсөвт өртөгтэй, төсвийн тухай хуулиар 902.1 сая төгрөгийн өртөгтэй 3 хөрөнгө оруулалтын ажилд 652.1 сая төгрөгийн санхүүжилт батлагджээ. Үүнд: Цээл сумын ЗДТГ, иргэний танхимын барилга, Архуст сумын соёлын төвийн барилга, Эрдэнэсант сумын спорт соёлын төвийн барилгууд байна. Эдгээрээс Эрдэнэсант сумын барилга нь 2012 оноос он дамжиж хийгдэж байгаа их засвар, Цээл сумын барилгын үлдэгдэл санхүүжилтийг орон нутгийн төсвөөс хийсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу "Монгол улсын 2014 оны төсвийн тухай хууль"-иар батлагдсан "Сумын төвийн шинэчлэл" 5.0 тэрбум төгрөгийн өртөгтэй төсөл, "Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кв-ын шугамын өргөтгөл, шинэчлэлт"-ийн ажлын хүрээнд хэрэгжүүлсэн 480.0 сая төгрөгийн өртөгтэй, нийт 5480.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлууд нь зураг, төсөвгүй хэрэгжсэн байна.

Зураг төсөв нь хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний хөрөнгийн эх үүсвэр нь төсвийн тухай хуулиар батлагдахдаа төсөвт өртөг, нэр, хэрэгжих хугацаа нь зөрүүтэй тусгагдсан, аймгаас төсвийн төсөлд санал нь яваагүй боловч санхүүжилт нь батлагдсан зэрэг асуудлууд байна. Үүнд:

- 2013 онд 837.5 сая төгрөгийн өртөгтэй Цээл сумын ЗДТГазар, иргэний танхимын барилгын зураг, төсөв хийгдэж, 2014 онд хөрөнгө оруулалтын эх үүсвэр нь батлагджээ. Монгол улсын 2014 оны төсвийн тухай хуулинд төсөл арга хэмжээний нэр нь "Цээл сумын иргэний танхимын барилгын үлдэгдэл санхүүжилт", хэрэгжих хугацаа 2012-2014 он, төсөвт өртөг нь 600.0 сая төгрөг
- Эрдэнэсант сумын спорт, соёлын барилгийн 2012 оноос он дамжин хийгдэж байгаа их засварын ажлын хэрэгжих хугацааг 2014 он, 327.7 сая төгрөгийн төсөвт өртөгийг 100.0 сая төгрөг гэж зөрүүтэй тусгагджээ.
- Бүрэн сумын сургуулийн их засвар 100.0 сая төгрөг, Баянцогт сумын сургуулийн их засвар 100.0 сая төгрөг, 5 дугаар сургуулийн спорт заалны их засвар 120.0 сая төгрөг, Баянчандмань сумын МСҮТ-ийн дээврийн их засвар 327.3 сая төгрөг, нийт 4 ажлын 647.3 сая төгрөг, Баянхангай сумын цэцэрлэгийн дээвэр, гадна засварын зардалд 70.0 сая төгрөгийн санал явуулсан боловч 30.0 сая төгрөгөөр нэмэгдэж 100.0 сая төгрөг болж ирсэн зэрэг аймгаас төсвийн төсөлд санал нь яваагүй байхад төсвийн тухай хуулиар нийт 677.3 сая төгрөг батлагджээ. Төсвийн тухай хуулийн 29.3-т "Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараахь байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана" гэсэн заалт зөрчигдсөн.

"Барилгын тухай хууль"-ийн 13.2-т "Гадаадын зээл, тусламж, **улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх**, эсхүл газар хөдлөлтийн 6-гаас дээш баллын бүсэд баригдах, барилга байгууламжийн зураг төсөл, инженер-геологийн төвөгшилтэй нөхцөлийн

судалгааны дүгнэлт, техник, эдийн засгийн үндэслэлд магадлал заавал хийлгэнэ” гэж заасан боловч дээрх их засварын ажлуудад магадлалын дүгнэлт гараагүй байна.

Монгол улсын Засгийн газар болон аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажлуудаас хуулийн дагуу зураг төсөв нь хийгдэж, хөрөнгийн эх үүсвэр нь батлагдсан дээрх 3 барилгаас бусад ажлууд зураг төсөвгүй батлагдаж, 2014 онд зураг, төсөв нь хийгджээ. Аудитын явцад зураг, төсөвтэй холбоотой дараахь зөрчлүүд гарлаа. Үүнд:

- Засгийн газраас хэрэгжүүлж буй “Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кв-ын шугамын өргөтгөл, шинэчлэлт”-ийг Цээл, Сүмбэр, Заамар, Сэргэлэн, Эрдэнэ, Баян өнжүүл гэсэн 6 суманд хэрэгжүүлэхээр 480.0 сая төгрөг төсөвт өртөгтэй ажилд санхүүжилт батлажээ. Гэтэл 3 сум нь 2014 онд хийлгэсэн зураг төсөвтэй, 3 суманд зураг, төсөв байхгүй байна. Энэ нь Төсвийн тухай” хуулийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэсэн заалтыг зөрчсөн байна.
- Аймгийн 2014 оны төсвийн төслөөс гадна нэмэгдэж ирсэн зураг, төсөв нь хийгдээгүй 5 барилгын 677.3 сая төгрөг болон бусад 431.0 сая төгрөгийн барилгын их засварын ажлуудын санхүүжилт зураг, төсөвгүй батлагджээ. Жишээлбэл: 276.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Баянжаргалан сумын цэцэрлэгийн их засвар нь төсвийн тухай хуулиар 150.0 сая төгрөг, Архуст сумын 10 ортой ЭМТ-ийн 197.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга 178.0 сая төгрөг гэх мэтээр 2014 оны төсвийн тухай хуулинд тусгагдсан өртөг болон мэргэжлийн байгууллагаар тооцуулсан төсөвт өртөг нь зөрүүтэй байна. Энэ нь Төсвийн тухай” хуулийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэсэн заалтыг зөрчсөн байна.
-
- Салбар яамдаас эрх шилжиж ирсэн 9 ажил буюу 1303.0 сая төгрөгийн хяналтын төсөвт өртөгтэй, төсвийн тухай хуулиар 1108.3 сая төгрөгийн өртөгтэй, хөрөнгө оруулалт, их засварын ажлын зураг, төсөв нь 2014 онд хийгджээ.

Зураг, төсөвгүй ажилд санхүүжилт батлагдаж ирснээс санхүүжилтийн эх үүсвэрт багтаан төсвийг бууруулах, барилгын ажил дутуу хийгдэх, хяналтын төсвөөс хэтэрсэн үнээр худалдан авалт хийх зэрэг зөрчлүүд гарлаа. Жишээлбэл:

-Баянцогт сумын сургуулийн их засварт 100.4 сая төгрөг батлагджээ. Батлагдсан хөрөнгийн эх үүсвэрт багтаан дээвэр болон хэсэгчилсэн дотор заслын ажлын төсвийг БХБ-ын сайдын 2012 оны 18 тоот тушаалаар бууруулж тооцсон

-Баянжаргалан сумын цэцэрлэгийн их засварт 150.0 сая төгрөг батлагджээ. Зураг, төсвийг хийлгэхэд 276.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын төсөв гарсан байна. Уг ажлын төсвийг бууруулахын тулд БХБ-ын сайдын 2012 оны 18 тоот тушаалаар тооцож, 250.1 сая төгрөг болгож бууруулсан

- Эрдэнэсант сумын залуучуудын соёл, спортын төвийн барилгын 327.7 сая төгрөгийн төсөвт өртөг нь 2012 онд ЗТБХБ-ын сайдын 2009 оны 263 тоот тушаалаар тооцогдсон бөгөөд 2014 онд ажил гүйцэтгүүлэхдээ хуучин төсвөөр тендер шалгаруулалтыг явуулж, ажил гүйцэтгүүлсэн

- ЭМ-ийн сайдын 2014 оны 288 тоот тушаалаар сайдын багцын "Гэнэтийн хүчин зүйлийн дагуу хийгдэх засварын төсөв"-өөс Баянжаргалан, Алтанбулаг сумдын халаалтын шугам, тогооны ажлын засварт 32.8 сая төгрөг батлагдаж иржээ. Засварын ажлыг хийлгэхээр зураг, төсөв хийлгэхэд 71.2 сая төгрөг болсон бөгөөд батлагдсан хөрөнгө хүрэлцэхгүйгээс засварын ажлыг хувааж дутуу хийсэн

-Засгийн газраас хэрэгжүүлж буй 6 сумын 0.4 квт-ын цахилгааны шугамын шинэчлэлийн ажлыг батлагдсан санхүүжилтэд багтаан хяналтын төсөв хэтрүүлж гэрээ байгуулан, ажил гүйцэтгүүлсэн байна. Энэ нь МУ-ын Сангийн сайдын 2012 оны 290 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”-ын 3.25-д “барилга, байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн заалт зөрчигджээ.

А.2 ХАА-г хуулийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан уу?

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсвийг бус хуулиар батлагдсан санхүүжилтийг тусгаж, мөрдөж байна.

2014 онд Төв аймагт “Монгол улсын 2014 оны төсвийн тухай хууль”-аар 7490.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд 7000.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжиж хийгдсэн байна. Эдгээр ажлуудаас Цээл сумын ЗДТГазар, иргэний танхимаас бусад хөрөнгө оруулалт, их засварын ажлын Монгол улсын 2014 оны төсвийн тухай хуулинд тусгагдсан төсөвт өртөг, батлагдсан санхүүжилтийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ. Жишээлбэл:

-Баянцогт сумын сургуулийн их засварт 100.4 сая төгрөг батлагдсан бөгөөд уг төсөвт багтаан төсвийг БХБ-ын сайдын 18 тоот тушаалаар бууруулж

-Баянжаргалан сумын цэцэрлэгийн их засварт 150.0 сая төгрөг батлагджээ. Тус барилгын засварын ажлын төсөвт өртөг нь 276.7 сая төгрөг бөгөөд төсвийг бууруулахын тулд БХБ-ын сайдын 18 тоот тушаалаар тооцож, 250 сая төгрөг болгож

-Эрдэнэсант сумын спорт, соёлын төвийн барилгын 327.7 сая төгрөгийн төсөвт өртөг нь ЗТБХБ-ын сайдын 2009 оны 263 тоот тушаалаар тооцогдсон

-Засгийн газраас хэрэгжүүлж буй 6 сумын 0.4 квт-ын цахилгааны шугамын шинэчлэлийн ажлыг батлагдсан төсвөөр бус батлагдсан санхүүжилтэд багтаан хяналтын төсөв хэтрүүлж худалдан авах ажиллагааг явуулжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийхээр төлөвлөгдсөн 14 ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТухай хуулинд заасан төсөвт өртгийн үнийн хязгаарт багтаан явуулж нээлттэй тендер шалгаруулалтаар 11, харьцуулалтын аргаар 2 гүйцэтгэчийг сонгон шалгаруулж, шууд гэрээг 1 гүйцэтгэгчтэй байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий захиалагчийг томилжээ. Мөн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг зохион байгуулах үнэлгээний хороог захирамжаар томилж ажиллуулсан байна.

Үнэлгээний хороо аймгийн Засаг даргын захирамжаар томилогдож, тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгох хүртэл 35-90 хоног зарцуулжээ. Баянцогт сумын сургуулийн засварт 90 хоног, Баянжаргалан сумын цэцэрлэгийн их засварт 84 хоног буюу хамгийн олон хоног зарцуулжээ. Баянцогт сумын сургуулийн засварын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийн нээлтэд 4 компани оролцож, шаардлага хангасан компани байхгүй тул тендерийг дахин зарлаж гүйцэтгэчийг шалгаруулсан байна. Баянжаргалан сумын 250.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цэцэрлэгийн их засварт 2014 оны төсвийн тухай хуулиар 150.0 сая төгрөг батлагдсан. Үлдэгдэл санхүүжилтийг 2015 онд санхүүжүүлэхээр тендер зарлагдаж тендерийг 2 удаа зарласан боловч эхний тендер оролцогч байхгүй, дараагийнх ажлын тоо хэмжээг дутуу

ирүүлсэн, шаардлага хангасан материал ирүүлээгүй учраас тендерийг хүчингүйд тооцож шууд гэрээ байгуулжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Монгол улсын 2014 оны төсвийн тухай хууль”-аар батлагдсан “Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд “Лүн сумын төвийн айл, өрх, албан байгууллагыг цэвэр, бохир, ус дулаанд холбох цэвэрлэх байгууламж байгуулах” 5.0 тэрбум төгрөгийн өртөгтэй төслийн ажлыг БХБ-ын сайдын 3 сарын 7-ны өдрийн 32 тоот тушаалаар аймгийн Засаг дарга нарт эрх шилжүүлжээ. ЗГХЭГ-ын 3 сарын 19-ны өдрийн ХЭГ/479 тоот албан тоотоор “ажлыг 2014 онд багтааж дуусган, төлбөр тооцоог санхүүгийн жилд багтааж гүйцэтгэсэн байх”, БХБ-ны 3 сарын 20-ны өдрийн 8/836 тоот албан бичигт “Зураг, төсөв гүйцэтгэх жишиг үнэ болон зураг, төсөл боловсруулах даалгаврыг бусад холбогдох баримт, материалын хамт яаралтай ирүүлж, баталгаажуулан, санхүүжилтийг шийдвэрлүүлж, тендер шалгаруулалтыг зохион байгуулах гэсэн байна. ЗГ-аас өгсөн чиглэлийн дагуу 4 сарын 1-ний өдрөөс хойш тендер зарлагдахгүй болоод байгаа тул хуваарилсан хөрөнгө хураагдах нөхцөл үүсэх” тухай албан тоотуудыг ирүүлжээ. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 7 сарын 2-ны өдрийн хуралдааны 36 дугаар тэмдэглэлд “Сумын төвийн шинэчлэл төсөл”-ийн хүрээнд зарим сумдад тендер зарлагдсан боловч оролцогч санал ирүүлээгүй, шаардлага хангасан оролцогч шалгараагүй, тендерийн маргаан гарсны улмаас тендерийг дахин зарлан дүгнэх, сонгон шалгаруулах хугацаагүй болсон, төсвийн жилд багтахаргүй болсон зэргийг харгалзан үзэж холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ шууд байгуулах нөхцөл, бололцоог эрэлхийлж, Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд тусгагдсан тухайн ажлыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайханд даалгав” гэсэн албан бичиг иржээ. Аймгийн Засаг дарга 3 сарын 27-нд үнэлгээний хороо байгуулах захирамж гаргаж, түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр гүйцэтгэх ажлын тендерийн урилгыг 4 сарын 1-нд нийтэлсэн байна. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалт явагдаж, түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр 6 сарын 12-ноос 11 сарын 30-ны өдөр хийж гүйцэтгэхээр 4978.9 сая төгрөгийн гэрээг “Ану сервис” ХХК-тай 6 сарын 9-нд байгуулжээ. Тус төслийн сумын төвийн айл, өрх, албан байгууллагыг цэвэр, бохир, ус дулаанд холбох цэвэрлэх байгууламж байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ТББ-ийн ажлын даалгаварт

-Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, ус, дулаан болон цахилгаан хангамж, холбоо дохиолол, ариутгах татуургын гадна шугам сүлжээний зураг төсөл боловсруулах болон угсралтын ажлыг гүйцэтгэх, барилга, байгууламжийн засвар болон тохижилт, бүтээн байгуулалтын ажлууд оржээ.

Аудитын явцад ХАА-тай холбоотой дараахь зөрчлүүд илэрлээ.

- Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Монгол улсын 2014 оны төсвийн тухай хууль”-аар батлагдсан “Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кв-ын шугамын өргөтгөл, шинэчлэлт”-ийн ажлын хүрээнд хэрэгжүүлсэн 480.0 сая төгрөгийн өртөгтэй 2014 оны төсвийн тухай хуулиар 240.0 сая төгрөг, 2015 онд 240.0 сая төгрөгийг санхүүжүүлэх 6 сумын 0.4 кв-ын шугамын шинэчлэлийн ажлын захиалагчаар аймгийн Засаг даргын тамгын газрыг томилж, худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ. Тендер зарлагдснаас хойш ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орж тендер шалгаруулах хугацааг хойшлуулсан тухай албан тоотыг тендерт оролцохоор хүсэлтээ ирүүлж ТББ худалдаж авсан 8 компанид хүргүүлжээ. Тендерийн нээлтэд 2 компани материалаа ирүүлж, Гэгээн цайдам ХХК шалгарч 6 сумын 6 багцад гэрээ байгуулсан байна. Ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орсон тухай албан тоот нь хавсралтгүй, ямар өөрчлөлт орсон нь тодорхойгүй байна. Энэ ажилд хяналтын зураг, төсөвгүй хөрөнгийн эх үүсвэр батлагдсан бөгөөд хяналтын зураг, төсвийг 2014 онд хийлгэсэн гэх боловч Цээл, Сүмбэр, Заамар сумд нь 225.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Сэргэлэн, Эрдэнэ, Баян-Өнжүүл сумдын хяналтын төсөв байхгүй байна. Аймаг дахь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ компаний иргэдэд үйлчлэх төвийн дарга Л.Батболд даргатай үнэлгээний хороо нь зураг, төсөв нь

хийгдсэн дээрхи 3 суманд хяналтын төсвийг 12.5 сая төгрөгөөр хэтрүүлж гэрээ байгуулах эрх олгожээ. Мөн Сэргэлэн, Эрдэнэ, Баян өнжүүл зэрэг сумдтай 236.4 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан бөгөөд хэдэн төгрөгийн төсөвт өртөгтэй ажил болох нь тодорхой бус байна.

- Архуст сумын соёлын төвийн барилгын их засварын гүйцэтгэгчээр шалгарсан Людмила ХХК-д 5 сарын 27-нд гэрээ байгуулах эрх олгох тухай албан тоотыг хүргүүлж, 6 сарын 5-ны өдөр 202.1 сая төгрөгийн өртөгтэй ажилд 185.9 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулжээ. Тус компаний тусгай зөвшөөрлийн хугацаа 2014 оны 6 сарын 10-нд буюу ажил гүйцэтгэх хугацаанд дуусч байгаа боловч аймгийн худалдан авах ажиллагааны албаны дарга Э.Амарсайхан даргатай үнэлгээний хороо нь тендерт шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгожээ. Шалгалтын хугацаанд үнэлгээний хороо нь тусгай зөвшөөрлийн сунгалтын талаархи тодруулгыг бичгээр авсан гэх боловч тендерийн үнэлгээ хийсэн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл дээр Людмила ХХК-ий тусгай зөвшөөрлийн хугацаа болон тодруулга авах талаар тэмдэглэгдээгүй байна.
- Баянчандмань сумын МСҮТ-ийн дээврийн засварын ажлын тендерийг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон худалдан авах ажиллагааны албаны дарга Э.Амарсайхан даргатай үнэлгээний хороо зохион байгуулж хийжээ. Тендерт Эл Си Би ХХК шалгарч, 327.7 сая төгрөгийн өртөгтэй ажлыг 316.0 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулжээ. Шалгалтын явцад тендерийн эх баримт дахь тусгай зөвшөөрөл нь “Өндөр жинст” ХХК-ий тусгай зөвшөөрөлтэй, үнэлгээний хороо нь холбогдох байгууллагаас тодруулга аваагүй, үнэлгээний хорооны дарга Э.Амарсайхан нь тусгай зөвшөөрөлгүй, санхүүгийн тайлан наториатаар баталгаажуулж байгаа гэж тэмдэглэл хөтөлсөн боловч тендер үнэлэхдээ компаний тусгай зөвшөөрлийг тендерийн баримтанд ирүүлсэн өөр компаний тусгай зөвшөөрлөөр үнэлсэн байна. Энэ талаар аймгийн ХАААлба болон үнэлгээний хорооны даргаас тодруулж хуулбар хувийг шалгаж үзлээ. Хуулбар хувь дахь тусгай зөвшөөрөл нь скайнердсан, хуудсыг баталгаажуулсан тамга нь байхгүй, тендерийн гүйцэтгэл дэх тусгай зөвшөөрлийн наториатаар баталгаажуулсан он, сар, өдөр, тамга нь хоорондоо зөрүүтэй байна. Тендер шалгаруулалтад нийт 7 компанийг үнэлсэн бөгөөд Эл Си Би ХХК нь дээрээсээ 2 дахь үнийн саналыг ирүүлсэн байна.
- Бүрэн сумын сургуулийн их засварын ажлын тендерт Төв цогт өлзийт ХХК, Арбулаг ХХК гэсэн 2 аж ахуйн нэгж материалаа ирүүлжээ. “Арбулаг” ХХК-ий тендерийн баримт бичигт захиалагч болох ГХБХГ-ын даргаас “Ар булаг” ХХК нь үйл ажиллагаа, ур чадвар сайтай, мэргэжлийн гүйцэтгэгч байгууллага болохыг тодорхойлсон тодорхойлолт ирүүлжээ. Энэ нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой.... байх зарчмыг баримтлана”, 50.1-д “ХАА-нд төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих болон бусад үүрэгтэй оролцож байгаа төрийн албан хаагч шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх” гэсэн заалтуудыг зөрчжээ.
- Цээл сумын ЗДТГазар, иргэний танхимын барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар Цээл сумын ЗДТГ-т эрх шилжүүлж гүйцэтгүүлсэн байна. Тус барилгын хяналтын төсөвт өртөг буюу тендер шалгаруулалт зохион байгуулах өртөг нь 837.5 сая төгрөг бөгөөд үүнд зураг төсвийн үнэ 12.9 сая төгрөг тооцогдсон байна. Тендер шалгаруулалтад “Анте” ХХК, “Дархан үйлс” ХХК-ууд оролцож, Э.Амарсайхан даргатай үнэлгээний хороо 790.0 сая төгрөгөөр ажил гүйцэтгэх гэрээг “Дархан үйлс” ХХК-тай байгуулах эрх олгожээ. Цээл сумын ЗДТГ, иргэний танхимын барилгын ажлын тендерт 2 компаний ирүүлсэн ТББ-ийг үзэхэд Антек ХХК 796.0 сая төгрөгийн үнийн санал ирүүлжээ. Тус компани зураг төсвийн үнэ 12.9 сая төгрөгийг оруулж тооцсон боловч тендерийн

баталгаа ирүүлээгүйгээс ерөнхий шаардлага хангахгүй болсноос хасагдаж “Дархан үйлс” ХХК-ийг шалгаруулсан байна.

Тендер шалгаруулалтыг зохион байгуулсан үнэлгээний хороо буюу аймгийн ХААА-ны дарга, мэргэжилтнүүд нь тодорхой ААН-үүдэд давуу эрх олгож, тендер шалгаруулалтыг хууль бус явуулж, гэрээ байгуулж, ажил гүйцэтгүүлсэн байна. Мөн зураг, төсөвгүй ажилд хөрөнгө батлагдаж ирснээр төсөв хэтрүүлж гэрээ байгуулах нөхцөл бүрджээ.

А.3 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн үү?

Яамд нь худалдан авах ажиллагааг нь зохион байгуулсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт орон нутагт хангалтгүй хэрэгжиж байна.

Төв аймагт “Монгол улсын 2014 оны төсвийн тухай хууль”-аар 7 сайдын багцаас нийт 9100.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 хөрөнгө оруулалт, их засварын ажилд 7450.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдан 9295.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдаж, хөрөнгө оруулалтын ажлууд хийгджээ. Эдгээр ажлуудаас 7090.0 сая төгрөгийн өртөгтэй 3 ажил нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд, 2010.4 сая төгрөгийн өртөгтэй 12 ажил нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу хэрэгжсэн байна.

2014 онд хийгдсэн томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил нь 5.0 тэрбум төгрөгийн өртөгтэй Лүн сумын төвийн айл, өрх, албан байгууллагыг цэвэр, бохир, ус дулаанд холбох, цэвэрлэх байгууламж байгуулах, 1610.0 сая төгрөгийн өртөгтэй 3 сумын халаалтын зуух, дулааны шугам сүлжээ барих, 837.5 сая төгрөгийн өртөгтэй Цээл сумын ЗДТГазар, иргэний танхимын барилгын ажил, 480.0 сая төгрөгийн өртөгтэй 0.4 квт-ын цахилгааны шугамын шинэчлэлийн ажлууд байна.

Хөрөнгө оруулалт нь, шинээр хийгдсэн 7927.5 сая төгрөгийн өртөгтэй 4 хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил, 1833.4 сая төгрөгийн өртөгтэй 9 их засварын ажлууд байна. Жишээлбэл:

- Аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “Иргэний танхимыг төрийн байгууллагуудаас боловсруулан гаргаж буй бодлого шийдвэрт иргэд санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх хэлбэрээр ажиллуулна” гэсэн зорилтын хүрээнд Цээл суманд ЗДТГазар, иргэний танхимын барилгыг 790.0 сая төгрөгөөр барьж ашиглалтанд оруулжээ.

Цээл сумын ЗДТГазар, иргэний танхимын барилга



-Лүн суманд хэрэгжиж буй 5.0 тэрбум төгрөгийн өртөгтэй “Сумын төвийн шинэчлэл” төсөл нь сумын төвийн айл, өрх, албан байгууллагыг цэвэр, бохир ус, дулаанд холбох, цэвэрлэх байгууламж байгуулах зорилгоор хэрэгжүүлжээ. Төв аймгийн Лүн сумын нийт нутаг дэвсгэр 2529.55 га, 824өрх 2609 хүн амтай, 394 өрх сумын төвд оршин суудаг, Лүн сумын төвөөр баруун чиглэлийн аймгуудыг холбодог улсын чанартай авто зам дайран өнгөрдөг, сургууль, цэцэрлэг, соёлын төв, эмнэлэг, хуучин ЗДТГазар буюу одоогийн ахуйн үйлчилгээний төв зэрэг төсвийн 5 байгууллага өмнө нь дулааны нэгдсэн шугам сүлжээнд холбогдсон зэрэг давуу талуудтай юм. Сумын төвийн зарим байгууллага дулаанд холбогдсон давуу талыг ашиглан сумын төвд бүтээн байгуулалт, тохижилтийн ажил, зарим төсвийн байгууллагуудын гадна болон дотоод заслын ажлуудыг хийх гэрээ байгуулагджээ.

Лүн суманд хэрэгжсэн уг төсөл нь

1. 240.8 сая төгрөгийн өртөгтэй сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах,
 2. 2866.1 сая төгрөгийн өртөгтэй инженерийн шугам сүлжээ, барилга угсралтын ажил
 3. 1872.0 сая төгрөгийн өртөгтэй сумын төвийн барилга, байгууламжийн ажлууд,
- Нийт 4978.9 сая төгрөгийн өртөгтэй ажлууд байна.

Эдгээр ажлуудаас Ану сервис ХХК нь 3106.9 сая төгрөгийн өртөгтэй зураг төсөл, инженерийн шугам сүлжээний ажлыг, Төв аймгийн барилга угсралт, засварын ТЗМ ХХК /Төв аймгийн барилгачдын холбоо/ нь 1872.0 сая төгрөгийн өртөгтэй сумын төвийн барилга, байгууламжийн засвар, бүтээн байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэх гэрээг байгуулсан байна.

Ажлын явцад төслийн ажлын хүрээнд хийгдэх ажлын даалгаварт өөрчлөлт орж, БХБЯ-аар баталгаажуулсан байна.

Тус төслийн ажлын гэрээний хугацаа 11 сарын 30-нд дууссан боловч 2015 оны 3 сарын 3-ны өдөр 05/14 тоот гэрээгээр гэрээний хугацааг 2015 оны 6 сарын 15-ны өдрийн дотор ашиглалтад оруулахаар болжээ.

Лүн сумын төвийн зарим байгууллагууд өмнө нь төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон байсан учраас сумын төвд тохижилт хийх боломж үүсч 1872.0 сая төгрөгийн зам, барилга, бүтээн байгуулалт, тохижилтийн ажлууд хийгджээ. Энэ ажлын хүрээнд сумын хуучин ашиглалтгүй байсан соёлын төвийн барилгад засвар хийн халаалт, цэвэр, бохир усны шугаманд холбож 340.3 сая төгрөгийн өртөгтэй засварын ажил хийж сумын ЗДТГ-ын барилгыг ашиглалтанд оруулсан байна. 2013 онд ЗДТГ-ыг шинээр бариулахаар /зургийн шифр:ЭЭП-07/13/ 1112.5 сая төгрөгийн өртөгтэй барилгын зураг, төсвийг ЗГХЭГ-т хүргүүлээд байжээ.

Лүн сумын Засаг даргын тамгын газар



Өмнө

одоо

Мөн гэрэлтүүлэг, авто зогсоол, авто зам, явган хүний зам, төсвийн байгууллагуудын гадна фасад, тохижилтийн ажлууд, цэвэр бохир усны шугамтай холбоотойгоор төсвийн байгууллагуудын ариун цэврийн өрөөг тохижуулах зэрэг олон ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Гэвч 109.3 сая төгрөгийн өртөгтэй гэрэлтүүлгийн цахилгааны төлбөр, урсгал зардлыг төлөх хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүйгээс ашиглалтгүй байна.

Засгийн газраас 3 суманд төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлж буй 1610.0 сая төгрөгийн өртөгтэй төвлөрсөн дулаан хангамж төсөл, 6 суманд хэрэгжиж буй 480.0 сая төгрөгийн өртөгтэй 0.4квт-ын шугамын шинэчлэлийн ажлууд нь улсын төсвөөс 2014 онд авахаар батлагдсан санхүүжилтаа бүрэн авсан боловч гэрээний хугацаа хэтэрсэн, ажлыг улсын комисс хүлээж аваагүй, ажлын гүйцэтгэл дутуу байна.

-Эрчим хүчний сайдын багцаас “Сумдын төвлөрсөн дулаан хангамж” төсөл арга хэмжээний хүрээнд аймгийн Баян өнжүүл, Баянхангай, Өндөрширээт гэсэн 3 суманд 1610.0 сая төгрөгийн халаалтын зуухны газар, дулааны шугам сүлжээ барих төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээг 2014 оны 8 сарын 27-ны өдрийн ЭХА-057/04 тоот гэрээгээр 2014 оны 9 дүгээр сарын 1-нээс 2014 оны 10 дугаар сарын 15-ны өдөр дуусгаж, улсын комисст хүлээлгэн өгөхөөр “Эл Си Би” ХХК-тай байгуулжээ. Тус компани нь “Эрчим хүчний тухай хууль”-ийн 12.1-т “Хуулийн этгээд дараахь үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ: Үүнд:

12.1.2. дулаан үйлдвэрлэх;

12.1.4. дулаан дамжуулах;

12.1.7. дулаан түгээх;

12.1.11. эрчим хүчний барилга байгууламж барих гэсэн байна. Гэвч “Эл Си Би” ХХК нь тусгай зөвшөөрөлгүй, ажил гүйцэтгэх гэрээг “Термокалор” ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулагдсны дараа буюу 9 сарын 15-нд байгуулжээ. Энэ нь “Барилгын тухай” хуулийн 12.3-т “Тендер шалгаруулалтад шалгарсан иргэн, хуулийн этгээд нь тендерээр авсан эрхээ бусдад шилжүүлэх, худалдахыг хориглоно.” гэсэн заалт зөрчигджээ.

Гэрээгээр улсын төсвөөс 450.0 сая төгрөгийн санхүүжилт хийх, компанийн өөрийн хөрөнгөөр 1160.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр батлагджээ. Халаалтын зуух, дулааны шугам сүлжээ барих төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар хийх төслийн шалгаруулалтыг ЭХЯам-наас зохион байгуулж, гэрээг ЭХЯам болон аймгийн Засаг дарга, түүний ЗДТГ, сумын Засаг дарга нартай байгуулжээ. 1.3-т “Энэхүү гэрээний 1.2-т заагдсан санхүүжилтийн хэмжээгээр талууд эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд өмчлөлийн асуудлыг оруулсан хөрөнгийн хэмжээгээр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлогдоно” гэсэн боловч ажлын гүйцэтгэл сум тус бүрт улсын төсвөөс санхүүжигдэх мөнгөн дүнгийн 95 хувь буюу 142.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, өөрийн хөрөнгөөр хийгдсэн ажил байхгүй байхад санхүүжилтийг олгосон байна.

-6 сумын 0.4 квт-ын шугамын шинэчлэлийн хяналтын зураг төсөвгүй ажилд санхүүжилт батлагдснаас батлагдсан санхүүжилтэд багтаан төсөвт өртгийг хэтрүүлж ХАА-г явуулж, гэрээ байгуулагджээ. Цээл, Сүмбэр, Заамар сумдын 225.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд 237.2 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж, Сэргэлэн, Эрдэнэ, Баян өнжүүл сумдын хяналтын төсөв байхгүй 237.4 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан байна. Гүйцэтгэгч “Гэгээн цайдам” ХХК нь 2014 оны 7 сарын 7-ноос 2014 оны 8 дугаар сарын 29-ны өдөр ашиглалтанд оруулах гэрээ байгуулсан боловч 3 сумын гэрээний хугацаа хэтэрсэн, комиссын актаар хүлээж аваагүй, 3 сумын ажлыг актаар хүлээж авсан боловч, данс бүртгэлд тусгаагүй байна.

Мөн Эрдэнэсант сумын спорт, соёлын төвийн барилгын 327.7 сая төгрөгийн төсөвт өртөг нь ЗТБХБ-ын сайдын 2009 оны 263 тоот тушаалаар тооцогдсон. Тус барилгын ажлыг батлагдсан санхүүжилтэд багтаан ажлыг хувааж хийснээр тухайн барилга ашиглалтад орох хугацаа уртасч, төсөвт өртөгт зөрүү гарчээ.

Аудитын явцад салбар яаман дээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажил гүйцэтгэж байгаа компаниуд орон нутагтай ямар нэгэн харьцаа байдаггүй, ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй, чанарын шаардлага хангахгүй барилга барьж ашиглалтад оруулдаг, гэрээний хугацаа хэтрүүлдэг, орон нутгаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлдэггүй зэрэг зөрчлүүд гарлаа. Жишээлбэл:

-Зуунмод сумын 5 багийн нутагт 414.5 сая төгрөгийн өртөгтэй, модон өрөгт бүтээц бүхий 100 хүүхдийн цэцэрлэгийг 2012 оны 12 сарын 21-нээс 2013 оны 7 сарын 15-ны өдрийн дотор ашиглалтад оруулах гэрээг БСШУЯ-тай байгуулсан Карго лэнд ХХК өнөөдрийг хүртэл тус барилгыг барьж дуусаагүй, ашиглалтад оруулаагүй байна. Аймгийн Засаг дарга нь 2014 оны 11 сард ажлыг хурдавчлуулах, ашиглалтанд оруулах хүртэлх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг томилж ажилуулжээ. Хууль зүйн хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг нь 3 удаа гүйцэтгэгчтэй уулзалт зохион байгуулж, 136.0 сая төгрөгийн хийгдээгүй ажлын жагсаалтыг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөн, БСШУЯ-нд албан бичиг хүргүүлсэн боловч үр дүн гараагүй байна.

*БСШУЯ-ны гэрээгээр Зуунмод сумын 5 багийн
нутагт баригдсан 100 хүүхдийн цэцэрлэг*



Гүйцэтгэгч нь Карго лэнд ХХК

-2009 оны 11 сард ашиглалтад орсон 389.8 сая төгрөгийн өртөгтэй халдварт, сүрьеэгийн 30 ортой эмнэлэг, шүүх эмгэг, анатомийн барилгыг ЭМЯ-тай гэрээ байгуулж Агенист ХХК хийж гүйцэтгэжээ. Тус эмнэлгийн барилгын агааржуулалтын систем ажилладаггүй, халаалт нь шаардлагатай хэмжээнд хүртэл халдаггүйгээс цонхнууд нь мөстөж цантаад хагардаг, дээврээс ус гоождог, үүний улмаас гадна, дотор хана, таазны шавар нурж, чийгшилтийн улмаас мөөгөнцөр үүсч халдвартын эмнэлэг нь өөрөө халдварт өвчин үүсгэх газар болсон байна. Тус барилгыг ашиглалтанд орсны дараа жил буюу 2010 оноос эхлэн эмнэлгийн удирдлагаас барилгын талаар үүсээд байгаа нөхцөл байдлын талаар мэдэгдэж ЭМЯ-нд 9 удаа албан тоот хүргүүлж, МХГ-ын улсын байцаагчийн үйл ажиллагааг түр зогсоох тухай акт гарсан боловч ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна.

ЭМЯ-тай гэрээ байгуулж халдварт, сүрьеэгийн 30 ортой эмнэлэг, шүүх эмгэг, анатомийн барилга



Гүйцэтгэгч нь Агенист ХХК

А.4 Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавьж буй захиалагчийн болон техник хяналтын үйл ажиллагаа үр дүнтэй юу?

Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавьж буй захиалагчийн болон техник хяналт хангалтгүй байна.

2014 онд Төв аймагт “Монгол улсын 2014 оны төсвийн тухай хууль”-аар 7 сайдын багцаас нийт 9100.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 хөрөнгө оруулалт, их засварын ажил хийгдсэн бөгөөд эдгээрийн техник хяналтын зардлын 132.5 сая төгрөг төвлөрөхөөс, Лүн сумын “Сумын төвийн шинэчлэл” төслийн ТХЗардал 83.0 сая төгрөгний 30 хувийг БХБЯ-нд төвлөрүүлэх гэрээ хийгдэж, аймгийн БХБА-ны дансанд нийт 107.6 сая төгрөгийн орлого төвлөрөхөөс 35.6 сая төгрөг төвлөрчээ. 71.9 сая төгрөгийн техник хяналтын зардал төвлөрөөгүй шалтгаан нь Цээл сумын ЗДТГазар, иргэний танхимын санхүүжилтэд 206.0 сая төгрөг дутуу санхүүжигдсэн бөгөөд уг барилгын захиалагчийн хяналтын зардал 13.8 сая төгрөг, Лүн сумын төслийн ТХЗардал 58.1 сая төгрөг нь БХБЯ-наас хийгдсэн санхүүжилт 12 сарын 30-ны өдөр хийгдэж тухайн ондоо багтаж санхүүжилт хийгдээгүйгээс болсон байна.

Улс, орон нутгийн төсвөөс хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажилд аймгийн ХБХ-ийн мэргэжилтнүүд болон ГХБХБГ-ын мэргэжилтнүүд хяналт тавьж байна. 2014 онд 4.6 сая төгрөгийг БХБА-ны данснаас зарцуулж, харилцахын хуулгаар сумдад ажиллах томилолт, шатахууны зардал гарчээ. Хяналт тавьсан томилолтын баримтыг шалгахад ажлын явцад хяналт тавих, ажил хүлээж авах комиссын ажлын хэсгийн томилолт, шатахуунд зарцуулагджээ. Хяналтын зардалд зарцуулагдсан зардлын баримтаас харахад ХБХ-ийн мэргэжилтнүүд томилолт, ажлын удирдамж байхгүй, эргээд ажлаа тайлагнасан, хяналт хийсэн тухай баримт байхгүй 2.4 сая төгрөг зарцуулжээ.

Хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийн баримттай танилцахад дараахь зөрчлүүд илэрлээ.

-100.0 сая төгрөгийн өртөгтэй Баянцогт сумын сургуулийн их засварын ажил 8 сарын 11-нээс 9 сарын 8-ны өдөр дуусгахаар гэрээ байгуулагджээ. Уг ажлыг гүйцэтгэгч “Шүр ар жүр ар” ХХК нь гэрээ байгуулснаас 4 хоногийн дараа буюу 8 сарын 15-нд ажлын гүйцэтгэлийг 72.7 хувьтай гаргаж 69.8 сая төгрөгийн гүйцэтгэлийн баримтыг гаргаж өгснийг ГХБХГ-ын мэргэжилтэн хянаж баталгаажуулсан байна.

-Цээл сумын ЗДТГазар, иргэний танхимын барилгын зохиогчийн хяналтын зардлыг хуульд заасан хэмжээнээс илүү тооцож гэрээ байгуулжээ. Тус барилгын техник хяналтын зардал нь 14.4 сая төгрөг бөгөөд "Тоонот констракшн" ХХК-тай зохиогчийн хяналт хийх 3.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан нь зохиогчийн хяналтын зардлын гэрээ 800.0 мянган төгрөгөөр илүү байгуулагдсан байна. Мөн зохиогчийн хяналтын зардалд 1.5 сая төгрөгийг сумын ОНХС-аас шилжүүлжээ.

-Аймгийн ГХБХГазарт "Ану сервис" ХХК –ий 11 сарын 30-ны өдөр ажлын гүйцэтгэл гаргасан баримтаар "Лүн сумын шинэчлэл" төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг 87.2 хувь буюу 4336.9 сая төгрөгөөр гаргаж, санхүүжилт авсан байна. Уг гүйцэтгэлд 1.ТЗМ ХХК-ий гүйцэтгэсэн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлууд 95 хувьтай 1758.7 сая төгрөг, 2.Ану сервис ХХК-ий ажлын гүйцэтгэл 83.0 хувьтай нийт 2580.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарчээ. Аудитаар ажлын гүйцэтгэл гаргасан баримттай, ажлын явцыг газар дээр нь очиж танилцахад дараахь зөрчлүүд илэрлээ. Ажлын гүйцэтгэлийн баримт, хийсэн ажил нь хоорондоо зөрсөн, зарим ажлуудын гүйцэтгэл дутуу байна.

Үүнд: 1.ТЗМ ХХК-ий гүйцэтгэсэн барилга, байгууламжийн ажлуудаас:

-98 хувийн гүйцэтгэлтэй 65.2 сая төгрөгийн өртөгтэй 780 м-ийн урттай ерийн ус зайлуулах суваг, гүүрийн ажил

-99 хувийн гүйцэтгэлтэй 49.6 сая төгрөгийн өртөгтэй 510 м урттай авто замын дагуух хашааны ажил дутуу хийгдсэн.

2.Ану сервис ХХК-ий гүйцэтгэсэн зураг төсөл, инженерийн шугам сүлжээний ажлаас:

-100 хувийн гүйцэтгэлтэй 240.0 сая төгрөгийн өртөгтэй зураг төсөв боловсруулах ажил

-97 хувийн гүйцэтгэлтэй 300.3 сая төгрөгийн өртөгтэй халаалтын зуухны угсралтын ажлууд хийгдээгүй.

-98 хувийн гүйцэтгэлтэй 694.6 сая төгрөгийн өртөгтэй гадна дулааны шугам сүлжээ, 415.4 сая төгрөгийн өртөгтэй цэвэр усан хангамжийн шугам сүлжээ, 334.9 сая төгрөгийн өртөгтэй ариутгах, татуургын ажлууд дутуу хийгдсэн зэрэг зөрчлүүд илэрлээ.





Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавигдаж буй захиалагчийн болон техник хяналт нь хангалтгүй байгаагаас гүйцэтгэгч нь ажлын гүйцэтгэлийг буруу гаргах, хяналт тавьж буй ажилтнууд нь тодорхой удирдамжгүй орон нутагт ажиллаж, ажлаа тайлагнаагүй байгаа нь хяналтын ажил хангалтгүй байгааг харуулж байна. Мөн Төв аймаг нь 27 сумтай бөгөөд Улс, орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж байгаа ажлуудад хяналт тавих мэргэжилтнүүдийн тоо хангалтгүй байна. Учир нь ГХБХГ-т ажиллаж байгаа мэргэжилтнүүд нь захиалагчийн хяналтын ажлыг хийдэг бөгөөд ХО-ын ажилд хяналт тавихаас гадна зарим зураг, төсвийн ажлыг хийдэг, хөрөнгө оруулалтын ажил нь улирлын чанартай байдаг зэргээс шалтгаалан ажлын ачаалал ихтэй, хийгдэж байгаа хөрөнгө оруулалт бүрт хүрч хангалттай хяналт тавьж чаддаггүй байна.

A.5 ХО-ын гүйцэтгэлийг бодитой дүгнэж, данс бүртгэлд тусгаж, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцсон уу?

Орон нутагт салбар яамдтай гэрээ байгуулж ажил гүйцэтгэж байгаа, гэрээний үүргээ биелүүлээгүй компаниудтай хариуцлага тооцогдохгүй байна.

2014 онд Засгийн газраас хийгдэж буй 3 төсөл, арга хэмжээний ажил нь гүйцэтгэл дутуу, гэрээний хугацаа хэтэрсэн, 2014 онд улсын төсвөөс батлагдсан санхүүжилтаа 2 төсөл нь 100 хувь, 1 төсөл нь 80 гаруй хувийг авсан байна. Лүн сумын ТЗМ ХХК-ий гүйцэтгэсэн 1872.0 сая төгрөгийн өртөгтэй барилга, байгууламжийн ажлыг барилга байгууламж, ашиглалтад оруулах комиссын актаар хүлээж авсан боловч 4978.9 сая төгрөгийн өртөгтэй төслийн ажлыг улсын комисс хүлээж аваагүй тул данс бүртгэлд тусгаагүй байна. 6 суманд хийгдэж буй 0.4квт-ын цахилгааны шугамын шинэчлэлийн ажлын Цээл, Сүмбэр, Заамар сумдын гэрээний хугацаа хэтэрсэн, улсын комисс хүлээж аваагүй, Сэргэлэн, Эрдэнэ, Баян өнжүүл сумдын ажлыг барилга байгууламж, ашиглалтад оруулах комиссын актаар хүлээж авсан боловч данс бүртгэлд тусгаагүй, ямар нэгэн хариуцлага тооцогдоогүй байна.

Харин салбар яамдаас эрх нь шилжиж хийгдсэн ихэнх ажлууд бүрэн хийгдэж, улсын комиссын барилга, байгууламж ашиглалтанд хүлээлгэж өгөх комисс актаар хүлээн авч, ашиглалтанд оруулсан байхад салбар яамдаас худалдан авах ажиллагааг нь зохион байгуулж, гэрээ байгуулж ажил гүйцэтгэсэн компаниудын ажилд хаанаас хэн хяналт тавих нь тодорхой бус, хяналт байхгүйгээс гэрээний хугацаа хэтэрсэн, ажлууд нь чанаргүй хийгдэж, ашиглалтанд ороогүй, ашиглалтанд орсон боловч чанарын шаардлага хангахгүй байхад ямар нэгэн хариуцлага тооцоогүй байна. Жишээлбэл:

2012 онд баригдаж эхэлсэн Зуунмод сумын 5 багийн нутагт 414.5 сая төгрөгийн өртөгтэй, модон өрөгт бүтээц бүхий 100 хүүхдийн цэцэрлэг, 2009 оны 11 сард ашиглалтад орсон 389.8 сая төгрөгийн өртөгтэй халдварт, сүрьеэгийн 30 ортой эмнэлэг, шүүх эмгэг, анатомийн барилга гэх мэт

Цээл сумын ЗДТГазар, иргэний танхимын 837.5 сая төгрөгийн өртөгтэй барилгын ажилд улсын төсвөөс 350.0 сая төгрөг батлагдсан боловч 339.0 сая төгрөг, аймгаас 245.0 сая төгрөг батлагдснаас 244.9 сая төгрөг, нийт 583.9 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, улсын төсвөөс 11.0 сая төгрөг дутуу санхүүжигджээ.

Захиалагчаас гэрээний хугацаа хэтрүүлсэн 3 компанид дутуу гүйцэтгэлийн мөнгөн дүнд хоногийн 0.03 хувийн 895.5 мянган төгрөгийн алданги тооцжээ. Үүнд: Архуст сумын соёлын төвийн их засварын ажлыг гүйцэтгэсэн “Людмила” ХХК-д 306.8 мянган төгрөг, Эрдэнэсант сумын соёл, спорт төвийн их засварын ажлыг гүйцэтгэгч “Төв Цогт өлзийт” ХХК-д 305.7 мянган төгрөг, Архуст сумын 10 ортой ЭМТ-ийн барилгын засварын ажлыг гүйцэтгэгч “Инса” ХХК-д 283.0 мянган төгрөгийн алданги тооцжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн үү?

Бүлэг 2

Орон нутгийн төсвөөр хийгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь үр дүнтэй хэрэгжсэн байна.

Б.1 ХО-ын төсөл, арга хэмжээг орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэн оновчтой төлөвлөсөн үү?

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлууд нь орон нутгийн хэрэгцээ шаардлагыг хангасан байна.

Аймгийн ИТХ-ын 2013 оны 6 дугаар хуралдааны 03 тоот тогтоолоор “аймгийн 2014 оны төсөв”-ийг батлаж, 2015 оны 03 сарын 27-ны өдрийн 10 дугаар хуралдааны 07 тоот тогтоолоор тодотгосон байна. 2014 оны төсвийн жилд аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгийн зардлын хэмжээг 3891.3 сая төгрөгөөр баталсан. Үүнд:

- 1.Замын сангийн хөрөнгө оруулалт 291.5 сая төгрөг
- 2.Аймгийн Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт 3433.7 сая төгрөг
- 3.Орон нутгийн хөрөнгө оруулалт 166.0 сая төгрөг

Нийт 3891.3 сая төгрөг

Мөн аймгийн ИТХ-ын 2014 оны 7 дугаар хуралдааны 3 тоот тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн урд оны шилжих үлдэгдлээс санхүүжүүлэх 1382.3 сая төгрөгийн 16 төсөл арга, хэмжээг жагсаалтаар батласны 11 нь 1043.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил бөгөөд төсвийн хэмнэлтээс 474.5 сая төгрөг зарцуулахаар батлагдсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын 166.0 сая төгрөг, төсвийн хэмнэлтийн 474.5 сая төгрөгийн зардлууд жагсаалтаар батлагдаагүй байна. Харин жагсаалтаар батлагдсан урд оны төсвийн шилжих үлдэгдлээс 1043.7 сая төгрөг, замын сангаас 291.5 сая төгрөг гэсэн 2 эх үүсвэрээр нийт 1335.2 сая төгрөгийн 17 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр батлажээ. Үүнд: урд оны хөрөнгө оруулалтын үлдэгдэл санхүүжилт 35.0 сая төгрөг, улсын төсвийн хөрөнгийн оруулалтын зөрүүг санхүүжүүлэхэд 245.0 сая төгрөг батлагджээ.

2014 онд хийхээр батлагдсан 15 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний 1221.2 сая төгрөгнөөс зураг төсвийн үнэнд 36.5 сая төгрөг, авто машин худалдан авахад 120.0 сая төгрөг, шинээр хийгдэх 545.0 сая төгрөгийн 5 хөрөнгө оруулалтын ажил, 348.7 сая төгрөгийн 6 засварын ажил, урсгал зардал буюу орон нутгийн замын сангийн орлого төвлөрүүлэх зардалд 5.0 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 166.0 сая төгрөг байна. Үүнээс 4 сумын ТАХ-ын 4 айлын орон сууцны 320 сая төгрөгийн барилга угсралтын ажлыг сумдад эрх шилжүүлж, 50.0 сая төгрөгийн Баян-Өнжүүл сумын ахуй үйлчилгээний төвийн ажил хийгдээгүй байна.

Аймгийн ИТХ-аар батлагдсан санхүүжилтээр 2014 онд шинээр 80.0 сая төгрөгөөр Баянхошуу багийн ахуй үйлчилгээний төвийн барилга, 100.0 сая төгрөгөөр Алтанбулаг сумын ахуй үйлчилгээ, бизнес төвийн барилга, тоног төхөөрөмж, 135.0 сая төгрөгөөр 1000 айлын орон сууцны гаднах авто зам, талбайн тохижилт гэсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлууд, 50.0 сая төгрөгийн Аргалтант сумын цэвэр, бохир усны шугамын шинэчлэлийн ажил, 25.0 сая төгрөгөөр Баянөнжүүл сумын ерөнхий төлөвлөгөө, 23.0 сая төгрөгөөр Баянхошуу багийн уулзвараас а25 кодтой авто замын уулзвар хүртэлх зураг хийлгэхээр гэрээ байгуулжээ.

Эдгээр ажлуудаас 166.1 сая төгрөгийн өртөгтэй Баянхошуу багийн ахуй үйлчилгээний төвийн барилгын ажилд 80.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, оёдол, халуун ус, угаалга, интернет кафе, үсчин гэсэн гэр хороололд үйлчилгээг нэг дор төвлөрүүлсэн үйлчилгээний төвийг байгуулснаас гадна цэвэр, бохир ус, худаг, халаалтын асуудлыг шийдсэн байна.



Мөн Засгийн газраас хэрэгжүүлж буй 1000 айлын орон сууцны хороололын гадна зам, талбайн тохижилтийн ажлыг замын сангаас батлагдсан 135.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэжээ.

Б.2 ХАА-г хуулийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан уу?

Харьцуулалтын аргаар худалдан авах бараа, ажил, үйлчилгээг шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын санхүүжилт нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 8.1.1-д “харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”-ыг хангаж байгаа учраас нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглээгүй, харьцуулалт болон шууд худалдан авалтын аргыг ашиглаж гэрээгээр гүйцэтгэсэн байна.

Аудитын явцад дараахь зөрчил илэрлээ.

- ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 8.1.2-т “Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”-ын заалтыг зөрчиж 12.9 сая төгрөгийн аймгийн ЗДТГ-ын ухаалаг самбар, ИТХ-ын ажлын албанд хурлын хуралдаан

зохион байгуулахад нийт 27.9 сая төгрөгийн өртөгтэй 41 ширхэг зөөврийн компьютерийг гэрээ байгуулж шууд худалдан авалт хийжээ.

- Баяндэлгэр сумын ЗДТГ-аас 2014 оны 7 сарын 7-ны өдөр “дээврээс ус гоожиж, өрөөнүүд мөөгөнцөртөн ажиллах боломжгүй болсон тул 30.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дээврийн засварын зардалд 27.0 сая төгрөг шийдвэрлэж өгөх хүсэлтийг албан тоотоор ирүүлж, 9 сарын 19-ний өдөр аймгийн Засаг даргын захирамжаар 30.9 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэжээ. Уг засварын ажлын хөрөнгийн эх үүсвэр батлагдаагүй байхад ХАА өмнө нь буюу 6 сарын 11-нд хийгдсэн байна. Тендерийн хэмнэлт 3.9 сая төгрөгөөр ЗДТГ-ын байрны дотоод засварын ажлыг гүйцэтгэсэн. Тендер шалгаруулалтаар Нүүрэнтийн андууд ХХК шалгарсан бөгөөд тус компани барилга угсралтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлгүй, НД болон татварын албанд татвар хураамж төлдөггүй байна.
- Авто тээврийн хэрэгсэлд батлагдсан 2 автомашины 120.0 сая төгрөгийн худалдан авалтыг харьцуулалтын аргаар хийжээ. Зуунмод сум нь 60 сая төгрөгийн автомашиныг хувь хүнээс худалдаж авахдаа хувь хүний орлогын албан татвар 6.0 сая төгрөгийг суутгаж аваагүй.
- ГИХАлба нь Моннис ХХК-тай гэрээ байгуулж 58.0 сая төгрөгийн автомашин худалдан авсан боловч уг автомашиныг аймгийн орлогод бүртгэж, хүлээж аваагүй
- Аргалтант сумын цэцэрлэгийн 50.0 сая төгрөгийн цэвэр, бохир усны шугамын шинэчлэлийн ажлыг “Өрнөх цамхаг” ХХК-тай шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлэн ажлыг хүлээж авсан боловч хөрөнгөнд бүртгэж аваагүй
- Нийт 73.6 сая төгрөгийн өртөгтэй ТББ-уудын ордны засвар нь 50.0 сая төгрөгийн өртөгтэй дотор засал, 19.5 сая төгрөгийн өртөгтэй гадна зам талбайн засвар, 4.1 сая төгрөгийн өртөгтэй кабель шугамын засварын ажлууд байна. Эдгээр засварын ажлуудыг орон нутагт үйл ажиллагаа явуулдаг барилгын компани, АЗЗА ТӨК-аар бага зардлаар шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлжээ.

Б.3 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн үү?

Хөдөө орон нутгийн иргэд 3D кино театрт кино үздэг болсон байна.

2014 онд төсвийн хэмнэлтээс 474.6 сая төгрөг зарцуулахаар батлагдсны 337.2 сая төгрөгийг их засвар, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэлд үлдсэн 137.4 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Төсвийн хэмнэлтээс зарцуулсан хөрөнгө оруулалтын зардлууд нь:

-147.1 сая төгрөгийн 12 төрлийн тоног төхөөрөмж

-17.9 сая төгрөгийг автомашины сэлбэг хэрэгсэл, засварын зардалд /ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар/

-112.0 сая төгрөгийг 6 газрын их засварт, нийт 277.8 сая төгрөг зарцуулсан байна.

Авто замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан ажлуудаас гадна 16.3 сая төгрөгийн өртөгтэй “Солонго” цогцолборын өмнөх талбайн тохижилтын ажил, 30.0 сая төгрөгийн өртөгтэй Сүмбэр сумын Загдалын гүүрний засварын зардал зэрэг нийт 46.3 сая төгрөгийн батлагдаагүй зардалд санхүүжилт хийсэн нь цаг үеийн байдлаас шалтгаалан зайлшгүй хийгдсэн ажлууд байна.

- Орон нутгийн замын сангаас замын сангийн орлого төвлөрүүлэхэд 5.0 сая төгрөг батлагдаж 4.7 сая төгрөгийг гэрчилгээний үнэ, томилолт, шатахууны зардалд зарцуулсан
- Замын сангаас АТӨЯХ-ийн албан татварын 10 хувь болох 25.7 сая төгрөгийг албан журмын даатгагчдын холбоонд шилжүүлсэн.
- Авто замын сангаас Сүмбэр сумын гүүрийн засварт 30.0 сая төгрөгийг эрх шилжүүлэн гүйцэтгүүлжээ. Уг зардал нь замын сангийн зардалд батлагдаагүй байна.

- Хуваарилагдаагүй зардлаас Лүн сумын хашаа барих ажлыг 2014 оны 11 сарын 7-нд эхэлж 12 дугаар сарын 1-ны өдөр ашиглалтанд оруулахаар гэрээг “Нямхас” ХХК-тай байгуулж 20.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлсэн байна. Уг мөнгө санхүүгийн тайланд өр, авлагаар тусгагдаагүй, эргэн төлөгдөөгүй

46.9 сая төгрөгийн өртөгтэй 3D кино театрын тоног төхөөрөмж, түүнийг суурилуулах ажил, нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн засварт 29.7 сая төгрөг, 14.9 сая төгрөгийг Солонго цогцолборын гадна тохижилтод зарцуулсан байна. Үүнээс 46.9 сая төгрөгийн өртөгтэй 3D кино театрын тоног төхөөрөмж, суурилуулах ажлын 43.2 сая төгрөг нь гаальтай холбоотой зардлууд, 3.7 сая төгрөг нь ажлын хөлс, НЭ-ийн хүүхдийн тасгийн 29.7 сая төгрөгийн засварын ажлыг эрх шилжүүлж гүйцэтгүүлсэн байна. Мөн нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс рүү ахмадын сувилалын зардалд 60.1 сая төгрөгийн санхүүжилт хийсний 49.9 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд /цалин, хоол, гэрэл цахилгаан гэх мэт/, 10.2 сая төгрөгийг гал тогоо, угаалгын өрөөний тавилга, цагаан хэрэгсэл худалдаж авахад зарцуулжээ.

“Солонго цогцолбор” дахь 3D кино театр



Б.4 Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавьж буй захиалагчийн болон ТХ-ын үйл ажиллагаа үр дүнтэй юу?

Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавьж буй захиалагчийн болон техник хяналтын үйл ажиллагаа хангалтгүй байна.

Аймгийн төсвийн хөрөнгөөр 2014 онд хийгдсэн хөрөнгө оруулалтад:

- 1.Орон нутгийн хөрөнгө оруулалтаас 166.0 сая төгрөг батлагдсаны 120.6 сая төгрөг
 - 2.Орон нутгийн төсвийн урд оны шилжих үлдэгдлээс нийт 1382.3 сая төгрөг батлагдсаны 1043.7 сая төгрөг
 - 3.Авто замын сангаас 291.5 сая төгрөг 337.7 сая төгрөг
 - 4.Төсвийн хэмнэлтээс нийт 474.6 сая төгрөг батлагдсаны 337.2 сая төгрөгийг зарцуулж, 2014 онд нийтдээ аймгийн төсвийн 4 эх үүсвэрээс 1864.1 сая төгрөг батлагдаж 1703.0 сая төгрөгийг зарцуулжээ. Үүнд:
 - Шинэ барилга байгууламжид 1132.3 сая төгрөг батлагдаж 978.8 сая төгрөг
 - Засварт 236.5 сая төгрөг батлагдаж 257.3 сая төгрөг
 - Тоног төхөөрөмж 110.8 сая төгрөг батлагдаж 110.8 сая төгрөг
 - Тээврийн хэрэгсэл худалдан авах болон засвар үйлчилгээнд 137.9 сая төгрөг батлагдаж 135.9 сая төгрөг
 - Үйл ажиллагааны зардалд 90.7 сая төгрөг батлагдаж 90.4 сая төгрөг /Ахмадын сувилалын цалин, томилолт гэх мэт/
 - Өмнөх оны үлдэгдэл санхүүжилт 94.4 сая төгрөг
 - Зураг төсөвт 61.5 сая төгрөг батлагдаж 35.4 сая төгрөг зарцуулагджээ.
- 2014 онд хөрөнгө оруулалтад батлагдсан нийт 1864.1 сая төгрөгийн 61 хувь нь шинэ барилга байгууламж барихад зарцуулагдсан бөгөөд үүнд Цээл сумын ЗДТГазар, иргэний танхимын улсын төсвийн санхүүжилтийн зөрүүд 245.0 сая төгрөг, 1000 айлын орон сууцны хороолол авто зам барихад 148.6 сая төгрөг зарцуулагджээ.

Эдгээр хөрөнгө оруулалтын ажлуудаас техник хяналтын зардалтай холбоотой дараахь зөрчлүүд илэрлээ.

- Алтанбулаг сумын ахуй үйлчилгээ, бизнес төвийн сүүний цехийн барилга угсралтын ажилд нийт 100.0 сая төгрөг батлагджээ. Үүний 69.9 сая төгрөг нь барилга угсралтын ажил, 30.1 сая төгрөг нь тоног төхөөрөмж, түүнийг суурилуулах зардал байна. Ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, Дөкө комплекс ХХК-тай 68.7 сая төгрөгийн гэрээ байгуулж гүйцэтгүүлэхдээ техник хяналтын зардал 1.2 сая төгрөгийг тооцоогүй байна.
- ССАЖГ-ын барилгын гадна ариутгах татуургын ажлыг Төв Чандмань ДЭХГ-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн бөгөөд 0.1 сая төгрөгийн техник хяналтын зардал тооцоогүй,
- Баяндэлгэр сумын ЗДТГ-ын засварын зардлыг шууд зардлаар тооцож санхүүжүүлсэн тул техник хяналтын зардал тооцогдоогүй, “Солонго” цогцолборын гадна талбайн тохижилтын ажлын техник хяналтын зардал 0.3 сая төгрөгийг суутгаж аваагүй зөрчлүүд илэрлээ.

ГХБХГ-т ажиллаж байгаа мэргэжилтнүүд нь ажлын ачаалал ихтэй байдгаас хийгдэж байгаа хөрөнгө оруулалт бүрт хүрч хангалттай хяналт тавьж чаддаггүй байна.

Б.5 Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг бодитой дүгнэж, данс бүртгэлд тусгаж, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцсон уу?

107.8 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын данс бүртгэлтэй холбоотой дараахь зөрчлүүд илэрлээ.

-төсвийн шилжих үлдэгдлээс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн ГИХАлбанд Моннис ХХК-тай гэрээ байгуулж 58.0 сая төгрөгийн автомашин худалдан авсан боловч уг автомашиныг аймгийн орлогод бүртгэж, хүлээж аваагүй

-“Өрнөх цамхаг” ХХК нь Аргалант сумын цэцэрлэгийн цэвэр усны шугамын шинэчлэлийн ажлыг захиалагч болох аймгийн ЗДТГ-тай гэрээ байгуулж гүйцэтгэсэн. Уг 49.8 сая төгрөгийн өртөгтэй ажлыг комиссын актаар хүлээж авсан боловч орлого аваагүй, данс бүртгэлд тусгаагүй байна.

Хөрөнгө оруулалтын гэрээний үүрэг, хариуцлагатай холбоотой дараахь зөрчлүүд илэрлээ.

-Хуваарилагдаагүй зардлаас Лүн сумын хашаа барих ажлыг 2014 оны 11 сарын 7-нд эхэлж 12 дугаар сарын 1-ны өдөр ашиглалтанд оруулахаар гэрээг “Нямхас” ХХК-тай байгуулж 20.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилт,

-ГИХА-ы автомашинтай холбоотой ямар нэгэн арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байсан зэрэг зөрчилд аудитын явцад албан шаардлага бичигдлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1.Батлагдсан зураг төсөвгүй ажилд хөрөнгө батлах, батлагдсан зураг, төсвөөс бага өртгийг хуулинд тусгаж хөрөнгийн эх үүсвэрийг батласнаас, санхүүжилтийн эх үүсвэрт багтаан төсвийг хийж байна.

2.

3.Салбар яамд нь худалдан авах ажиллагааг нь зохион байгуулсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт орон нутагт хангалтгүй хэрэгжиж байна.

4.Улс, орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж байгаа ажлуудад хяналт тавих мэргэжилтнүүдийн тоо хангалтгүй байна. Учир нь ГХБХГ-т ажиллаж байгаа мэргэжилтнүүд нь захиалагчийн хяналтын ажлыг хийдэг бөгөөд ХО-ын ажилд хяналт тавихаас гадна зарим зураг, төсвийн ажлыг хийдэг, хөрөнгө оруулалтын ажил нь улирлын чанартай байдаг зэргээс шалтгаалан ажлын ачаалал ихтэй, хийгдэж байгаа хөрөнгө оруулалт бүрт хүрч хангалттай хяналт тавьж чаддаггүй байна.

5.Салбар яамдаас худалдан авах ажиллагааг нь зохион байгуулж, гэрээ байгуулж ажил гүйцэтгэсэн компаниудын ажилд хаанаас хэн хяналт тавих нь тодорхой бус, хяналт байхгүйгээс гэрээний хугацаа хэтэрсэн, ажлууд нь чанаргүй хийгдэж, ашиглалтанд ороогүй, ашиглалтанд орсон боловч чанарын шаардлага хангахгүй байхад ямар нэгэн хариуцлага тооцоогүй байна .

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн аймгийн Засаг дарга Д.Баярбат, Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Ү.Батчулуун, ГХБХБГазрын дарга М.Хүрэлбаатар нарт зөвлөх нь:

1.Батлагдсан зураг төсөвтэй ажилд хөрөнгө батлуулах, Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2012 оны 6 сарын 13-ны өдрийн 181 дүгээр тушаалаар баталсан “Барилгын төсөв зохиох дүрэм”-ийг хэрэгжүүлэх

2.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тухайн хөрөнгө оруулалтын ажлын батлагдсан төсөвт өртгийг мөрдөх

3.Орон нутагт салбар яамдаас эрх нь шилжиж хийгдэж байгаа ажлуудад тухайн яам, гүйцэтгэгч нартай орон нутгаас гэрээ байгуулж, хөрөнгө оруулалтыг үр дүнг сайжруулах

4.Улс, орон нутаг, орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажилд нь тавих хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулах

5. Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч нартай тооцох хариуцлагын талаар гэрээнд тодорхой тусгаж, хариуцлага тооцох

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал



**ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА**

41100 Зуунамод, Төв аймаг
Утас: 70273539, Факс: 70273579

2015. 4. 17 № 1/026

тантай -ны № -т

Шинжээчийн гаргасан дүгнэлтэд хариу тайлбар
өгөх тухай

ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ШИНЖЭЭЧ
ЗАГДСҮРЭН ТАНАА

Архуст сумын соёлын төвийн барилгын их засварын гүйцэтгэгчээр шалгарсан Людмила ХХК-д 5 сарын 27-нд гэрээ байгуулах эрх олгох тухай албан тоотыг хүргүүлж, 6 сарын 5-ны өдөр 202.1 сая төгрөгийн өртөгтэй ажилд 185.9 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулжээ. Тус компаний тусгай зөвшөөрлийн хугацаа 2014 оны 6 сарын 10-нд буюу ажил гүйцэтгэх хугацаанд дуусч байгаа боловч аймгийн худалдан авах ажиллагааны албаны дарга Э.Амарсайхан даргатай үнэлгээний хороо нь тендерт шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгожээ. Шалгалтын хугацаанд үнэлгээний хороо нь тусгай зөвшөөрлийн сунгалтын талаархи тодруулгыг бичгээр авсан гэх боловч тендерийн үнэлгээ хийсэн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл дээр Людмила ХХК-ны тусгай зөвшөөрлийн хугацаа болон тодруулга авах талаар тэмдэглэгдээгүй байна.

Хариу тайлбар:

Тендерийн баримт бичгийн ТӨӨЗ-ны 4.4 дэх хэсэгт Тендерт оролцогч нь эрх бүхий эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтад үндэслэн тогтооно. Гэсэн зааварчилгааны (в)-д ТШӨХ-д шаардсан бол тухайн төрлийн ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл,-тэй байх эсэхийг ТШӨХ-д Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх. **тийм**

2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилтын ажил

2.1.2. Мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил гэсэн заалтын дагуу тусгай зөвшөөрөл шаардсан болно. Энэхүү шаардлагыг хангаж буй эсэхэд үнэлгээг тухайн үнэлгээ хийх хугацаанд тусгай зөвшөөрөлтэй, тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болоогүй байсан тул тендерт оролцох эрх бүхий бус гэж үзэн дараагийн үнэлгээнд хамруулахгүй байх үндэслэлгүй юм. Тусгай зөвшөөрлийн хугацаагаа сунгуулах эс сунгуулах асуудал нь тусгай зөвшөөрөл олгогч байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын хоорондын байгуулсан гэрээгээр зохицуулагддаг тул захиалагч талаас тусгай зөвшөөрөл сунгаж буй талаархи тодруулгыг үнэлгээний хороо тендерийн үнэлгээний явцад авсан бөгөөд тусгай зөвшөөрөл албажих шатандаа гэсэн Тусгай зөвшөөрөл олгогч Барилгын хөгжлийн төвийн тодорхойлолтыг ирүүлсэн болно. Иймд Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусах гэж байна гэж үзэн үнэлгээнд хамруулахгүй байх үндэслэлгүй тул үнэлгээний хорооны гишүүд үнэлгээг хийж шийдвэр гаргасан.

Баянчандмань сумын МСҮТ-ийн дээврийн засварын ажлын тендерийг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон худалдан авах ажиллагааны албаны дарга

01100019

Э.Амарсайхан даргатай үнэлгээний хороо зохион байгуулж хийжээ. Тендерт Эл Си Би ХХК шалгарч, 327.7 сая төгрөгийн өртөгтэй ажлыг 316.0 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулжээ. Шалгалтын явцад тендерийн эх баримт дахь тусгай зөвшөөрөл нь "Өндөр жинст" ХХК-ий тусгай зөвшөөрөлтэй, үнэлгээний хороо нь холбогдох байгууллагаас тодруулга аваагүй, үнэлгээний хорооны дарга Э.Амарсайхан нь тусгай зөвшөөрөлгүй, санхүүгийн тайлан наториатаар баталгаажаагүй байна гэж тэмдэглэл хөтөлсөн боловч тендер үнэлэхдээ компаний тусгай зөвшөөрлийг тендерийн баримтанд ирүүлсэн өөр компаний тусгай зөвшөөрлөөр үнэлсэн байна. Энэ талаар аймгийн ХАААлба болон үнэлгээний хорооны даргаас тодруулахад хуулбар хувийг авчирч үзүүллээ. Хуулбар хувь дахь тусгай зөвшөөрөл нь скайнердсан, хуудсыг баталгаажуулсан тамга нь байхгүй, тендерийн гүйцэтгэл дэхь тусгай зөвшөөрлийн наториатаар баталгаажуулсан он, сар, өдөр, тамга нь хоорондоо зөрөөтэй байна. Тендер шалгаруулалтад нийт 7 компанийг үнэлсэн бөгөөд Эл Си Би ХХК нь дээрээсээ 2 дахь үнийн саналыг ирүүлсэн байна.

Хариу тайлбар:

Тухайн компани нь тендерийн эх хувьдаа Барилгын тусгай зөвшөөрлөө наториатаар баталгаажуулан хийгээгүй хуулбар хувьдаа оруулсан байсан нь тендерээс татгалзах ноцтой алдаа зөрчил гэж үзээгүй учраас үнэлгээний хороо тусгай зөвшөөрөл нь байна гэж үзээд тэмдэглэлдээ оруулсан юм. Мөн Үнэлгээний хорооны даргын хувьд Барилга хөгжлийн төвийн вэб сайтанд тусгай зөвшөөрөл эзэмшдэг бүх ААН байгууллагуудын бүртгэлээс шалган үзэж баталгаажуулж байсан.

• Цээл сумын ЗДТГазар, иргэний танхимын барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар Цээл сумын ЗДТГ-т эрх шилжүүлж гүйцэтгүүлсэн байна. Тус барилгын хяналтын төсөвт өртөг буюу тендер шалгаруулалт зохион байгуулах өртөг нь 837.5 сая төгрөг бөгөөд үүнд зураг төсвийн үнэ 12.9 сая төгрөг тооцогдсон байна. Тендер шалгаруулалтад "Анте" ХХК, "Дархан үйлс" ХХК-ууд оролцож, Э.Амарсайхан даргатай үнэлгээний хороо 790.0 сая төгрөгөөр ажил гүйцэтгэх гэрээг "Дархан үйлс" ХХК-тай байгуулах эрх олгожээ. 2 компаний тендерт ирүүлсэн ТББ-ийг үзэхэд Анте ХХК 796.0 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн бөгөөд төсөвтөө зураг төсвийн үнэ 12.9 сая төгрөгийг оруулж тооцжээ. Харин тендерт шалгарсан "Дархан үйлс" ХХК нь зураг төсвийн үнэ 12.9 сая төгрөгийг оруулж тооцоогүй байхад шалгаруулж гэрээ байгуулах эрх олгогдсон байна.

Хариу тайлбар:

Энэхүү хөрөнгө оруулалтын ажлыг Аймгийн засаг дарга Цээл сумын Засаг даргад эрх шилжүүлэн өгсөн бөгөөд Сэргэлэн суманд барьсан нэг загварын барилгын зураг төсөвтэй барилгын ажил байсан. Цээл сумын засаг дарга өөрийн захирамжаар үнэлгээний хороонд дарга хийгээд анх удаа сумандаа нээлттэй тендер зохион байгуулахад зааж зөвлөхийг санал болгосон. Өнөөдөр Төв аймгийн 27 суманд нээлттэй тендер зохион байгуулж үзсэн туршлагатай сум ховор бөгөөд ядаж АЗ сертификат-тай албан хаагч иргэд ховор учраас манай албанаас байнга сум орон нутагт очиж тендер зохион байгуулж өгдөг. Таны судлаж үзээд гаргасан алдааг тод санаж байна. Үнэхээр 2 компани санал ирүүлсэнээс Анте ХХК нь Тендерийн баталгаа дээрээ асуудал гаргаад ямар ч асуудалгүй тендер шалгаруулалтанд бүдэрсэн харин Дархан үйлс ХХК нь 837,5 сая төгрөгийн ажлыг 790 сая төгрөгөөр хийхээр санал өгсөн байсан. Энэ ажил нь үнэн бодит байдал дээр бараг концесс маягтай тухайн жилийн төсөв хөрөнгө нь 240 орчим сая төгрөг төсөвлөгдсөн дараагийн санхүүжилт нь тодорхойгүй байсан бөгөөд харин ч өөрийн хөрөнгөөр барьж

байгуулах санал өгч орж ирсэн компани байсан юм. Цээл сумын иргэд үнэлгээний хорооны гишүүдэд миний бие зураг төсвийн мөнгө төсөвт суугдаагүй байгаа шалтгаанаар тендер хүчингүй болно дахиад 1 сар хойшилж тендер шалгаруулалт явагдах хуулийн хугацаа байдаг хуулийн талаар тайлбарлахад хүлээж аваагүйн дээр Засаг Дарга Ганбат тай уулзуулж ямар ч байсан хугацаа алдахгүйгээр ажлаа эхлүүлэх санхүүжилтийг авч сумандаа тендерийг амжилттай хэрэгжүүлэх талаар туслалцаа хүссэн. Амьдрал дээр сум орон нутгийнхан өөрсдийн сумыг хөгжүүлэх шинэ барилга байшин барих энэхүү боломжоо алдахгүй гэж зүтгэн хүсэлт гаргасан байдал дээр нь би татгалзаж чадаагүй юм. Харин заавал энэ компанитайгаа зураг төсвийн тооцоо хийж тайландаа оруулаарай гэж зөвлөөд тендерийг хүчинтэй болгох тэдний саналд нэгдсэн нь үнэн. Үнэлгээний хорооны дийлэнх олонхи нэг санал гаргаад учирлан тайлбарласан ЗД-н саналыг хүлээн авсан нь бодит байдал дээр тендер будилуулсан гэдэг дүгнэлтэнд хүрэхгүй болов уу гэж тайлбарлаж байна.

Тендер шалгаруулалтыг зохион байгуулсан үнэлгээний хороо буюу аймгийн ХААА-ны дарга, мэргэжилтнүүд нь тодорхой ААН-үүдэд давуу эрх олгож, тендер шалгаруулалтыг хууль бус явуулж, гэрээ байгуулж, ажил гүйцэтгүүлсэн байна. Мөн хяналтын төсөвгүй ажилд хөрөнгө батлагдаж ирснээр төсөв хэтрүүлж гэрээ байгуулах нөхцөл бүрджээ.

Харуу тайлбар:

Үнэлгээний хорооны гишүүд бүгд тэгш эрхтэйгээр өөр өөрийн саналын эрхтэй ажилсан. Үнэлгээний хороонд ажиллаж байгаа Дарга нь илүү эрх эдэлдэггүй. Үнэлгээний хорооны гаргасан зөвлөмжийг захиалагч хууль бус гэж үзвэл хүлээж авахгүй байх бүрэн эрхтэй. /ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 46.1-46.7 хүртэлх/

ДАРГА  ЗАМАРСАЙХАН

Холбогдох байгууллагын саналын дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ**Холбогдох байгууллагын санал**

Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2015 оны 4 сарын 17-ны өдрийн А/26 тоот албан бичигт ирүүлсэн холбогдох санал, тайлбарын дагуу Цээл сумын ЗДТГазар, иргэний танхимын барилгын тендерийг үнэлсэн үнэлгээний бичиг, баримтанд “Антек” ХХК-ийг тендерийн баталгаа ирүүлээгүй гэж тэмдэглэгдсэн байх тул тайлангийн А2-т бичигдсэн: “Цээл сумын ЗДТГ, иргэний танхимын барилгын ажлын тендерт 2 компаний ирүүлсэн ТББ-ийг үзэхэд Антек ХХК 796.0 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн бөгөөд төсөвтөө зураг төсвийн үнэ 12.9 сая төгрөгийг оруулж тооцжээ. Харин тендерт шалгарсан “Дархан үйлс” ХХК нь зураг төсвийн үнэ 12.9 сая төгрөгийг оруулж тооцоогүй байхад шалгаруулж гэрээ байгуулах эрх олгогдсон байна” гэснийг

“Цээл сумын ЗДТГ, иргэний танхимын барилгын ажлын тендерт 2 компаний ирүүлсэн ТББ-ийг үзэхэд Антек ХХК 796.0 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн бөгөөд төсөвтөө зураг төсвийн үнэ 12.9 сая төгрөгийг оруулж тооцсон боловч тендерийн баталгаа ирүүлээгүйгээс ерөнхий шаардлага хангахгүй болсноос хасагдаж “Дархан үйлс” ХХК-ийг шалгаруулсан байна” гэж өөрчлөлт орууллаа.